



Хичээлийн сэдэв: ТӨРӨӨС ЯВУУЛСАН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА (1924-1940)




ТӨРӨӨС ШАШНЫ ТАЛААР ЯВУУЛСАН БОДЛОГО 1924-1940

АГУУЛГЫН ХҮРЭЭ

**Төрөөс шашны талаар
явуулсан бодлого**

Их хэлмэгдүүлэлт

Халх голын дайн





ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Төрөөс шашны талаар явуулсан бодлого, их хэлмэгдүүлэлт, халх голын дайны шалтгаан, үр дагавар, сургамжийг тодорхойлох



Харьцуулан
шинжлэх

Баримтыг
тайлбарлах

Түүхчлэх



ТӨРӨӨС ШАШНЫ ТАЛААР ЯВУУЛСАН БОДЛОГО

ТӨРӨӨС ШАШНЫ ТАЛААР ЯМАР БОДЛОГО БАРИМТАЛЖ БАЙСАН БЭ?



Эх сурвалж,
баримтууд

“Урьдын ван, гүн ба хутагт хувилгаад, жич орон хийдэд үргэлж суух санваартан, лам нар”

Анхдугаар Үндсэн хууль 35.3


“Шашин шүтлэгийн хэрэгт оролцогчид буюу **лам нарыг** албадан хар болгогчид, бас ардын шашин шүтлэгийг доромжлогчид **хийгээд шашныг хавчигчид** бүхнийг цээрлүүлэн шийтгэнэ”. Шашин шүтлэгийн заншлуудтай хориглох аргаар тэмцэж үл болно.

БНМАУ-ын XVII бага хурал

1934 онд хүрээ хийдийн дэргэдэх дацангууд ба **сүмд 18000** гаруй хөвгүүд шавилан сууж байсан бол улсын **сургуульд 5000** орчим хүүхэд суралцаж байлаа.

Монгол Улсын түүх. Тавдугаар боть. УБ., 2003.

ТӨРӨӨС ШАШНЫ ТАЛААР ЯВУУЛСАН БОДЛОГО





ТӨРӨӨС ШАШНЫ ТАЛААР ЯВУУЛСАН БОДЛОГО

Зэвсэг барин тэмцэх болсны шалтгаан юу байв.



Большевик нам,
Коминтерны удирдлага

МАХН богино хугацаанд
хувьсгалт аргаар
социализм байгуулах

Алдаатай бодлого

Эдийн засаг, нийгмийн
амьдралыг гүн гүнзгий
хямралд оруулсан.

Эсэргүүцлийн олон хэлбэр

Өмчөө дээрэмдүүлж,
шашнаа доромжлуулсан
олон түмэн зэвсэг барин
ТЭМЦСЭН.



ТӨРӨӨС ШАШНЫ ТАЛААР ЯВУУЛСАН БОДЛОГО

БАРИМТАД ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ ҮЗЬЕ



Сүүлийн сарын дотор **хувьсгалын эсэргүү** тэмцэл нь Хөвсгөл, Архангай, Завхан, Өвөрхангай зэргийн газруудад дэлгэрч, ардын хувьсгалт засгийг эсэргүүцсэн бослогын шинжтэй болж, нам, эвлэлийн гишүүд татагдан орж, хувьсгалын эсэргүү феодалууд ба **дээд лам нараар** удирдуулан явж буй.

МАХН-ын Төв Хороо, Хянан байцаах Төв комиссын хамтарсан онц III хурлын тогтоолд



“Харгис феодал, **лам нар сүм хийдийг** түшиглэн Японы империализмын дэмжлэгээр тус улсын баруун хэдэн аймагт **хувьсгалын эсэргүү бослого** гаргав”.

1954 онд хэвлэгдсэн “БНМАУ-ын түүх”



Судлаач Д. Цэрэнбалжир 700 хүний амь насыг бусниулсан, Д. Гомбосүрэн зэвсэгт бослогыг дарах явцад 2056 хүн амь үрэгдсэн. С. Ганболд 5976 буюу 2 талаас 6000 орчим хүн амь насаа алдсан. С. Л. Кузьмин босогчдын тоо 1915 хүн, засгийн газраас 409 хүн амь насаа алдсан гэж тэмдэглэжээ.



ТӨРӨӨС ШАШНЫ ТАЛААР ЯВУУЛСАН БОДЛОГО



Батболдын Түгж нь өөрийн сүүлчийн үг болгон "Ардын Нам, Ардын засаг Үндэсний гэх юм бүхнээ уландаа гишгэж, Улаан Оросын үзэл номлолыг дагаж дарвин, Ард түмнээ хар, шар, баян тарган хэмээн ялгаварлан харгислаж яргалаагүй бол, үе улирсан сүлд тахилга, судар ном, сүм хийд, шашин, соёлын өвийг устгаагүй бол Бослого хөдөлгөөн гарах шаардлага байгаагүй. Харин ч бид Ардын Нам, Ардын засгийг эсэргүүцээд байх зүйлгүй тул дэмжиж байлаа" гэж хэлсэн гэдэг.



ИХ ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ 1937-1940

Хэлмэгдүүлэлт хэдээс хэдэн онд үргэлжилсэн бэ?

Хэзээ эхэлсэн бэ? Шалтгаан нь юу байв.

Хэлмэгдүүлэлтийн ямар ямар хэлбэрүүд байдаг вэ?

Хэлмэгдүүлэлтийн гадаад, дотоод шалтгаан юу байв.


Хэлмэгдүүлэлтийн үр дагавар, сургамжийг юу гэж бодож байна.




ИХ ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ 1937-1940



1895-1937
П. Гэндэн



1887-1940
Лосолын Лааган



А. Амар
1886-1941



Д. Догсом
1884-1941

“...Том гүрэн жижиг улсыг эзэрхийлэхдээ удирдагчдыг нь баривчилдаг нь дандаа тохиолддог явдал. Зөвлөлт Холбоот улс Монголыг тусгаар улс гэж байгаа ч хэрэг дээрээ мөн л ингэж хандаж байдгийн бодит жишээ нь би өөрөө болоод байна”

А.Амар



ИХ ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ 1937-1940

ГАДААД ШАЛТГААН



Манж го – “Тоглоомын улс”



ЗХУ-ын удирдагчдын хардалт

ДОТООД ШАЛТГААН




Төр засгийн алдаатай
бодлого



Зөвлөлтийн нэр хүнд
унасан



ИХ ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ 1937-1940





ХАЛХ ГОЛЫН ДАЙН

Манж Го улс
БНМАУ-тай шууд
хиллэх болсон

1939.05.11 Японы
300 явган цэрэг
Монголын хил рүү
цөмөрсөн.

1939.06.20 Японы
150-д онгоц
Хамар давааг
бөмбөгдөв.

1939.07.08 -08.20
Шийдвэрлэх
тулаан

1939.09.16-нд
байлдааны үйл
ажиллагааг
зогсоосон.



ХАЛХ ГОЛЫН ДАЙН

Халх голын дайн зөвхөн
Халх голын дайн байсангүй
Хайртай бүхнээ дайснаас өмөөрсөн
Хамаг ардын дайн байлаа Д.Пүрэвдорж





ХАЛХ ГОЛЫН ДАЙН



“Монголчууд ийм цөөхүүлээ атлаа ийм өргөн уудам нутгийг эзэгнэж, хамгаалан оршин тогтноод байж чаддагын нууцыг би Халх голын дайнаас олж харлаа”

Зөвлөлтийн маршал Г. Жуков



Би хамгийн гайхалтай цэргийг Монгол цэрэг л гэнэ. Орос дайчин сүүлийн сумаа өөртөө үлдээдэг байхад Монгол цэрэг сүүлийн сумаа ч дайсандаа шигтгээд “нэгийг албал солио, хоёрыг албал хожоо” гэдэг. Бүх сумаа дуусчихаад өч төчнөөн дайсны эсрэг винтовоо далайгаад дайрч байсан монгол цэргийг би үзсэн юм шүү.

Хурандаа генерал И. А. Плиев



ХАЛХ ГОЛЫН ДАЙН

Халх голын дайны талаар судлаачид

Халхын голын дайны явцад байлдааны бүх төрлийг хамарсан нийт 101 томоохон тулаан болж, нийтдээ 74522 хүний хохирол учирснаас 28246 нь амь үрэгдсэн тооцоо бий. Халхын голын дайн нь харьцангуй бага нутаг дэвсгэрт болсон хэдий ч оролцсон хүн хүч, зэвсэг техникийн хэмжээ, орчин үеийн цэрэг техникийн бүх ололтыг ашигласнаараа онцлог бөгөөд дэлхийн хоёрдугаар дайны өмнөх томоохон байлдаан, түүний эхлэл болсон юм.

(Н.Хишигт)

Монгол Улс, монголчуудын хувьд Халх голын дайн нь хүчин буурай монгол орныг санаан зоргоор эзлэн, эрхшээлдээ орчуулчих боломжгүй, хүчирхэг хамгаалагч, өмгөөлөгчтэй болохыг санаархагч орон: Япон, Хятадад хатуу сануулга өгсөн.

(Т. Сүхбаатар)



ГЭРИЙН ДААЛГАВАР



Даалгаврын
хувилбарууд

Дараах сэдвүүдээс сонгон авч судлаарай. Үүнд:

- Ж. Лхүмбийн хэрэг, Гэндэн, Дэмидийн хэрэг, Улаан Пүрэвийн хэрэг, “Заговор хуйвалдаан”, Амар, Довчингийн хэрэг гэх мэт

“Хэлмэгдүүлэлтэд өртсөн эмэгтэйчүүд” сэдвээр зураг, эссэ, илтгэл сонгож бичээрэй

Ижил үйл явдлыг өгүүлсэн хэд хэдэн сурвалжуудыг сонгон авч дүн шинжилгээ хийгээрэй.





АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.